

Хүүхдэд зориулсан Библи
танилцуулж байна

Хайртай хүү
нь боол
болсон нь



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: Byron Unger; Lazarus

Найруулсан: M. Kerr; Sarah S.

Орчуулсан: Damdin Horolsuren

Бүтээсэн: Bible for Children
www.M1914.org

©2014 Bible for Children, Inc.

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



**Исаак маш аз жаргалтай байв. Учир
нь түүний хүү Иаков гэртээ ирсэн
байв.**




**Есав ч дүүгээ найрсгаар хүлээж
авсан бөгөөд нэгэн цагт тэр түүнийг
алах тангараг тавьсан
байсан юм.**




**Гэвч Иаковын хөвгүүд баярласангүй
учир эцэг нь тэдний бага дүүг нь их
хайрладаг байв.**




Иосеф нэгэн зүүд зүүдлээд, түүнийгээ
ах нартаа ярьсанд тэд түүнийг улам
үзэн ядах болжээ.



Тэр "миний боосон сүрэл
босоод зогсчхов. Гэтэл та нарын
боосон сүрэл миний сүрлийг тойрон
цуглараад, түүнд
мөргөцгөөв"
ГЭЖЭЭ.



Энэ зүүд Иосеф ах нараасаа илүү
чухал гэдгийг хэлсэн байв.



Иосефийн хоёр
дахь зүүдэнд нь
нар, сар одод
түүнд мөргөв.



Тэр энэ тухай ах
нартаа болон
эцэгтээ ярьсанд
тэр чи өөрийгөө
бусдаас дээгүүр
өргөмжиллөө
гэж түүнийг
зэмлэжээ.



**Нэгэн өдөр Иаков Иосеф хүүгээ хээр
талд очоод ах нар болон хонин сүргээ
эргээд ир гээд явуулжээ. Ах нар нь
түүнийг хараад
түүн уруу ирэв.**



**Тэд хоорондоо энэ зүүдлэгчийн
алцгаая гэж хоорондоо хэлэлцжээ.
Иосеф түүний өмнө аюул байгааг
мэдсэнгүй.**



**Том ах Реубен тэдэнтэй санал
нийлсэнгүй. Цус бүү урсга. "Хараач
тэнд нэг нүх байна.
Түүнийг энэ
нүхрүү хая" гэв.**



**Тэр дотроо дүүгээ аврах бодолтой
байлаа.**




**Иосефийг
ирэхэд тэд
түүнийг
барьж
аваад эцэг нь
хайртай хүүдээ
өмсүүлсэн
тансаг дээлийг
нь тайлж
авав.**



**Тэгээд
түүнийг
нүхэнд
шиджээ.**




**Реубенийг босож явсан
хойгуур Египетийг
зорьсон тэмээн
жингийн цуваа
ТЭДНИЙ**




**сууж байсан
газраар
өнгөрөв.**



**Иуда ах дүү нартаа
хандаж "Иосефийг
худалдацгаая" гэв.**




**Тэд худалдаачидтай
тохиролцов. Тэд
түүнийг хорин мөнгөн
зоосоор худалдав.**



**Нулимс болон айдас нөмөрсөн
Иосефийг тэмээн жингийн
цуваа төрсөн нутгаас
нь алс хол
уруу авч**

явлаа.





**Иосефийн ах
нар эцэгтээ
түүнийг
хээрийн зэрлэг
араатанд
идүүлсэн гэж
итгүүлэх гэж
түүнд "Энэ
Иосефийн дээл
биш үү?"**




Энэ дээл цус
болсон байна.
Бид үүнийг
хээр талаас
оллоо" гэв.




**Иаков хувцсаа
уран хүүгийнхээ
төлөө гашуудав.
Түүнийг хэн ч
тайвшруулж
чадсангүй.**



**Иосеф Египетэд
ирээд айж бас
ганцаардсан байх
магадгүй тэр
гэрээ маш их
санасан байх.**




Гэвч тэр тэндээс
зугтаагүй юм.
Тэр нэгэн Египет
хүн харуулын
захирагч
Потифарын гэрт
боол болсон байв.



**Потифар
Иосефийг өдөр
бүр шаргуу сайн
ажиллаж байгааг
хараад түүнд
ИТГЭЖ найдав.**




**Нэгэн өдөр Потифар
"Бурхан чамтай хамт
байж чиний хийсэн
бүхнийг бүтэмжтэй
болгож байгааг би
харлаа
ГЭЖЭЭ.**




**Би чамайг гэрийнхээ
даамал болгож бүх
үйлчлэгч боолуудаа
чамаар захируулахыг
хүсэж
байна"**


ГЭВ.



**Бурхан Иосефийн
улмаас Потифартын
гэрийг ерөөж
арвин ургац
хураан
авав.**



**Одоо Иосеф
чухал хүн болсон
ч Бурханд итгэн
үйлчилсээр байв.
Гэвч Иосеф уруу
гай ирж байлаа.**



Потифарын эхнэр ёс бус эмэгтэй
байлаа. Тэр Иосефийг нөхрөө
болгохыг хүсэв.



**Иосеф дургүйцэв. Иосеф би
Потифарын эсрэг
Бурхандаа нүгэл
үйлдэхгүй гэв.**



Эмэгтэй хүчээр түүн уруу дайрахад
тэр зугтаан гарчээ.

Тэр эмэгтэй
түүний хувцсыг

авч

үлдэв.



**Потифарын эхнэр нөхөртөө
"Чиний боол над уруу дайрлаа" гэж
гомдоллоод "Хараач энд
түүний
хувцас
байна!"**




гэхэд Потифар ихэд уурлав.

Магадгүй тэр эхнэрээ худлаа ярьж
байгааг мэдсэн байх.



Гэхдээ тэр нэгэн зүйлийг хийх
хэрэгтэй. Тэр түүнийг яасан болоо?






Потифар Иосефийг
шоронд өгч
хориулжээ. Иосеф

ямар ч гэм буруугүй ч
уурлаж гомдолсонгүй.





Тэрээр харин ч
хатуу бэрхийг
сурч Бурханыг
алдаршуулж Бурхан
түүнийг ч ерөөж
байлаа.



Хайртай хүү нь боол болсон нь

Бурханы үг Библиээс авсан түүх

Эхлэл 37, Эхлэл 39

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.



**Хэрвээ та энэ үнэнд итгэж
байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй:
Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон
миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та
амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж
ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос
эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр
тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд
дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө
амьдрахад туслаач. Амен.**

**Библи уншиж өдөр бүр Бурхантай
ярилцаарай! Иохан 3:16**

